



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧИЙН 2021 ОНЫ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ГСА-2022/1/СТА-ТЕЗ

Тэргүүлэх аудитор: Б.Сарантуяа

Утас: 70543156 Цахим хаяг:

Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр

Утас: 70543179 Цахим хаяг:

Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Ц.Батсайхан

Утас: 70543151 Цахим хаяг:

Batsaikhants@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хуудас: www.audit.mn

Чойр хот 2022он

АГУУЛГА

<u>Тайланг бэлтгэсэн:</u>	
Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газар	Товчилсон үгийн тайлбар 4
Дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа	Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 5
Аудитын менежер Г.Наранбаяр	Төсвийн төлөвлөлтөд ахиц дэвшил гараагүй байна 7
Ахлах аудитор Ц.Батсайхан	1.1 Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу боловсруулсан байна. 7
	1.2 Төсвийн тухай хуульд заасан хязгаарыг баримтлаагүйгээс жил бүр суурь зарлагыг нэмэгдүүлэн баталсаар байна. 7
	1.3 Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас хянасан хязгаараас нэмэгдүүлэн баталж, зарцуулсан байна 10
	1.4 Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг 20.7 сая төгрөгөөр дутуу тооцсон байна..... 12
2022 оны 04 дүгээр сар	Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч зарим зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна. 13
	2.1 Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 46% буюу 2,772.8 сая төгрөгөөр давж биелсэн боловч 3 нэр төрлийн татварын орлого 66.2 сая төгрөгөөр тасарсан байна. 13
	2.2. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 51.0 сая төгрөг буюу 7.8%-иар давж биелсэн боловч түрээсийн орлогын төлөвлөгөө тасарсан байна 15
	2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 13.0% буюу 53.5 сая төгрөгөөр давж биелсэн байна. 16
	2.4. 2021 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 531.9 сая төгрөгөөр буурсан байна. 17
	2.5. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжигдсэн байна. 17
	2.6. ЭМДС-гаас авах санхүүжилт 25.5 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна. 18
	2.7. Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна. 18
	Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна. 18
	3.1 Аймгийн СТСХ нь байгууллагуудын хүсэлтийн дагуу батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зохицуулалт хийсэн байна. 18
	3.2 Төсвийн хэмнэлтийн 683.7 сая төгрөгийн 3.5 хувь нь бодит бус хэмнэлт байна. 20
	3.3 Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна..... 21

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
7054-3151, 7054-3179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:
Аймгийн Засаг даргын
тамгын газрын байр, 2
давхар, 205 тоот

	Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтэд тавих хяналт хангалтгүй байна. 22
	4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай байна. 22
	4.2 Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд бодитой үнэлгээ хийгээгүй байна. 23
	ДҮГНЭЛТ 24
	АУДИТЫН ЗӨВЛӨМЖ..... 24

Товчилсон үгийн тайлбар

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМХТЗ	Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл
АМХТЗ	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл
АТБӨЯХ	Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэл
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БТСГ	Биеийн тамирын спортын газар
БХНСАХЗ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал
ГБХЗХГ	Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДНС	Засаг даргын нөөц сан
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЗЗНДНТУТХ	Монгол улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХС	Сум хөгжүүлэх сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТТАМНАТ	Түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
УИХ	Улсын их хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ҮХХ	Үл хөдлөх хөрөнгө
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:

Аудитыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, “Аудитын төлөвлөгөө батлах тухай” Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/87 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.4-т заасны дагуу Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

Аудитын зорилт:

Орон нутгийн 2021 оны төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд:

- 2021 оны төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэл
- 2021 оны төсвийн зарлагын төлөвлөлт, гүйцэтгэл
- ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтот түвшин

Говьсүмбэр аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасны дагуу орон нутгийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл,
- Нэмэлт төсвийн гүйцэтгэл,
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн,

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны орон нутгийн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүнг УАГ, аймгийн ИТХ болон Төсвийн ерөнхийлөн захирагчид хуулийн хугацаанд хүргүүлж, аудитаар илэрсэн алдаа, зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитын хамарсан хүрээ:

Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжилт авдаг, орон нутгийн орлого бүрдүүлдэг байгууллага, аж ахуйн нэгж, ТЕЗ-ийн 2021 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа мэдээлэл болон бусад баримт материалуудад тулгуурлан гүйцэтгэлээ.

Аудитын арга зүй:

Аудитын явцад асуудлыг шинжлэхдээ аудитыг АДБОУС 1000-1800, Төрийн хяналт шалгалтын стандарт, Санхүүгийн аудитын гарын авлага, холбогдох журмуудыг ашиглахаас гадна холбогдох албан тушаалтантай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан, шаардлагатай мэдээ, судалгааг гаргуулан авч, тулган баталгаажуулах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, нотлох зүйл цуглуулж аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсрууллаа.

Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд: Аудитад дараах хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль,
- Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Төрийн аудитын тухай хууль

- Татварын багц хуулиуд
- Аймаг, сумын ИТХ-ын хуралдааны тогтоолууд
- Бусад холбогдох хууль тогтоомж, журам, заавар

Аудитыг гүйцэтгэсэн хугацаа, аудитын багийн бүрэлдэхүүн

Аудитыг Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, аудитын менежер Г.Наранбаяр үе шатны ажлын чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Ц.Батсайхан, 2022 оны 04 сарын 01-ний өдрөөс эхэлж, 2022 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд хийж гүйцэтгэв.

Үндсэн мэдээлэл:

2021 онд орон нутгийн төсөвт нийт 21,274.5 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр төлөвлөсөн байна. Эх үүсвэрийн хувьд:

- Орон нутгийн татварын орлогоос 5,166.5 сая,
- Сумдын татварын орлого 850.5 сая
- Татварын бус орлогоос 624.0 сая
- ОНХС-ийн нэгдсэн сангаас санхүүжилт 1,558.1 сая,
- Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт 9,039.3 сая,
- Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого 51.6 сая,
- Дансны эхний үлдэгдлээс 412.3 сая,
- Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтөөс 359.1 сая,
- Улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг 1,613.2 сая,
- ЭМДС-гаас 47.1 сая,
- 2020 оны тэнцлийн ашиг 1,552.8 сая төгрөгийг тус тус бүрдүүлж, төсвийг алдагдалгүй байхаар төлөвлөсөн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд 21,274.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас нийт зардлын гүйцэтгэл 19,377.1 сая төгрөг буюу 91.0 хувьтай байна.

Тайлант онд нийт 1,897.4 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан ба үүнээс 25.6 сая төгрөгийг улсын төсөвт, 1,186.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 2.0 сая төгрөгийг сумдын ЭМТ-үүд үлдэгдлээр тайлагнаж, 6,83.7 сая төгрөг нь бодит бус хэмнэлт байна. Үүнд:

1. 37 байгууллагын 389.2 сая төгрөгийн үлдэгдэл нь бодит хэмнэлт бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж бараа материалын зардал, нормативд зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал, төрийн өмчит байгууллагад олгох татаас урсгал шилжүүлэг зэрэг зардлууд хэмнэгдсэн байна
2. Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 855.6 сая төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдээгүй он дамжсан
3. Сумын ЭМТ-үүд нь 2.0 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.
4. Харин 683.7 сая төгрөг нь бодит бус хэмнэлт бөгөөд байгууллага болон эх үүсвэрээр нь харуулбал:
 - Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт 4.6 сая төгрөгөөр орлого тасалсантай холбоотой зардлыг санхүүжүүлээгүй /“Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ-ын 4.6 сая/
 - Тайлант онд Сүмбэр сум, Шивээговь сум СХС-гаас зээл олгоогүйгээс 282.8 сая,
 - Сумдын Эрүүл мэндийн төв эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлээгүйгээс ЭМДС-гаас 25.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан, /Шивээговь сумын ЭМТ 19.2 сая, Баянтал сумын ЭМТ 6.3 сая/
 - Аймаг, сумдын ОНХС-гийн ажил төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй он дамжсанаас 370.8 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Бүлэг 1

Төсвийн төлөвлөлтөд ахиц дэвшил гараагүй байна

1.1 Аймгийн ТЭЗ-ийн 2021 оны төсвийг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу боловсруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.



Сангийн сайдын “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж”-ийн хүрээнд аймгийн ТЭЗ-ийн 2021 оны төсвийн төсөл, 2022-2023 оны төсвийн төсөөллийг аймгийн СТСХ-ээс бэлтгэж, Сангийн яаманд хүргүүлсэн байна.

Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хууль 2020 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр Улсын Их Хурлаар хэлэлцэн батлагдаж, Сангийн сайдын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 4-1/7562 тоот албан бичгээр УИХ-аас батлагдсан төсвийг ирүүлсэн байна.

Монгол Улсын төсвийн нэгдмэл байдал, төсвийн сахилга батыг хангах зорилгоор орон нутгийн 2021 оны төсвийг боловсруулж батлахдаа дараах чиглэлийг баримталсан байна. Үүнд: Орлогын талаар

1. Хүү, торгуулийн орлогыг орлого нэр төрөл бүрээр бүртгэж, гүйцэтгэлийг төвлөрүүлэгч байгууллага бүрээр гаргах

2. Нийгмийн даатгалын болон татварын албаны цалингийн сангийн мэдээллийг нягтлан, цалин, хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах бусад орлогод ногдуулах албан татварын ногдуулалт, төлөлтийг хянах

3. Зам, тээврийн хөгжлийн яам, Авто тээврийн үндэсний төвийн мэдээллийн санд бүртгэгдсэн, тээврийн хэрэгслийн мэдээллийг татварын албаны бүртгэлийн мэдээлэлтэй тулгаж, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын ногдуулалт, төлөлтийг хянах, орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх

4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн бүх шатны засаг дарга, газрын албанаас олгосон газар эзэмших, ашиглах эрх, тэдгээрийн нэгж, талбаруудын мэдээллийг газрын кадастрын мэдээллийн санд бүртгэж, цахимжуулахад онцгой анхаарч, газрын төлбөрийн орлогыг бүрэн хураах

5. Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуультай хамт батлагдсан Малын тоо толгойн албан татварын тухай хуулийг орон нутгийн иргэдэд сурталчлан таниулах, 2021 оны сум, дүүргийн төсөвтэй хамт уг албан татварын хэмжээ, хөнгөлөлтийн хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан тогтоож, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд нэн яаралтай бүртгүүлэн 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжүүлж эхлэх Албан татварын хэмжээг тогтоож, сум дүүргийн орон нутгийн хөгжлийн санд төвлөрүүлэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Төсвийн тухай хуулийн 60.2.8-д заасан зориулалтын дагуу орлогыг иргэдийн саналд үндэслэн зарцуулах ажлыг зохион байгуулан хуулийн хэрэгжилтийг оны эхнээс хангаж ажиллахад онгой анхаарах

1.2 Төсвийн тухай хуульд заасан хязгаарыг баримтлаагүйгээс жил бүр суурь зарлагыг нэмэгдүүлэн баталсаар байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар жилийн төсвийн хязгаар нь орлогын доод, зарлагын дээд хэмжээ бөгөөд Сангийн яам 2021 оны төсвийн жилийн суурь орлогыг 5,778.0 сая, суурь зарлагыг 16,924.0 сая төгрөгөөр хянасныг нэмэгдүүлэн төлөвлөж батлуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн орлого, зарлагыг өмнөх онуудын орлого, зарлагын гүйцэтгэлд болон төсөвт байгууллагуудын ирүүлсэн саналд үндэслэн төлөвлөдөг боловч төсвийн орлого, зардлыг хянаж, төлөвлөхдөө суурь судалгаа, тоон мэдээнд үндэслээгүйгээс жил бүр аймгийн ИТХ-аар нэмэгдүүлэн батлуулж байна.

УИХ-аар батлагдсан Төсвийн тухай хуулиар орон нутгийн 2021 оны төсвийн нийт зарлагыг 16,924.0 сая төгрөгөөр баталсан. Үүнд:

- Төсвийн суурь зарлагыг 6,872.2 сая
- Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага 8,538.2 сая,
- ОНХС-ийн зарлага 1,513.6 сая

Аймгийн ИТХТ-ийн 2020.12.04-ний өдрийн 03, Сүмбэр сумын ИТХ-ын 2020.12.17-ны 07, Шивээговь сумын 2020.12.18-ны 09, Баянтал сумын 2020.12.21-ний 10 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 7,255.2 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагыг 8,538.2 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 1,188.6 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 1,895.4 сая, сумдын СХС-гийн зарлагыг 355.7 сая нийт 19,233.1 сая төгрөгөөр аймгийн 2021 оны төсвийг батлахдаа УИХ-аас баталсан төсвийг 2,309.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Төсвийн тодотголоор Аймгийн ИТХТ-ийн 2021.07.23-ний өдрийн 05, Сүмбэр сумын ИТХ-ын 2021.08.13-ны 03, Шивээговь сумын 2021.08.10-ны 04, Баянтал сумын 2021.07.30-ны 08 дугаар тус тус тогтоолоор суурь зарлагыг 357.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагыг 347.7 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 755.1 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 377.2 сая, сумдын СХС-гийн зарлагыг 3.3 сая нийт 1,840.9 сая төгрөгөөр нэмж, нийт 21,074.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн АИТХТ-ийн хурлаар төсөвт өөрчлөлт оруулаагүй байхад сумдын ИТХ-аас тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийг 200.5 сая төгрөгөөр нэмж, нийт 21,274.5 сая төгрөгөөр баталсан байна.

2021 оны орон нутгийн төсвийн орлого төлөвлөлтийн талаар:

2021 онд УИХ-аас анх баталсан 5,778.0 сая төгрөгийн орлогыг аймаг, сумдын ИТХ-аар 863.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлого 6,641.0 сая төгрөг төвлөрүүлэхээр батлуулсан байна.

УИХ-аас батлагдсан 2021 оны орон нутгийн орлогын төлөвлөгөөнд орсон өөрчлөлтийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №1

/сая төгрөгөөр/

Орлогын нэр төрөл	УИХ-аас баталсан орлого	Аймаг, сумдын ИТХ-аас баталсан орлого	Зөрүү
1	3	4	5=4-3
Татварын орлого	5,218.0	6,017.0	799.0
Татварын бус орлого	560.0	624.0	64.0
НИЙТ ДҮН	5,778.0	6,641.0	863.0

Хүснэгтээс харахад: УИХ-аас батлагдсан орлогын дүнг аймгийн ИТХ-ын тогтоолоор 14.9% буюу 863.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал, Орон нутгийн татварын орлогыг 799.0 сая төгрөгөөр буюу 15.3%-иар, татварын бус орлогыг 11.4% буюу 64.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн төлөвлөж баталсан байна.

Татварын орлогын төлөвлөгөөнд 8 нэр, төрлийн орлогыг 1,198.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 2 нэр төрлийн орлогыг 335.2 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

Нэмэгдүүлэн баталсан орлогыг нэр төрлөөр нь харуулбал:



Бууруулан баталсан орлогыг нэр төрлөөр нь харуулбал:



Орлого нэмэгдүүлж төлөвлөсөн шалтгаан нь цалин хөдөлмөрийн хөлс, шагнал урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого, дуудлага худалдааны орлого, газрын төлбөр, улсын тэмдэгтийн хураамжийн орлогуудыг өмнөх оны гүйцэтгэлд тулгуурлан, нэмж баталсан байна.

Орлого бууруулж төлөвлөсөн шалтгаан нь улс орон даяар ковид 19 цар тахалтай холбоотойгоор ААНБ-ын хэвийн үйл ажиллагаа доголдсон тул цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлогыг, бодит гүйцэтгэлд үндэслэн ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого, хувь хүний орлогын албан татварын буцаалтыг тус тус бууруулсан байна.

2021 оны батлагдсан орон нутгийн орлогын төлөвлөгөөг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №2		/сая төгрөгөөр/		
№	Орлогын нэр төрөл	2020 оны батлагдсан орлого	2021 оны батлагдсан орлого	Зөрүү
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	3,220.0	3,780.0	560.0
2	ХХОАТ-ын буцаан олголт	-195.4	-174.4	21.0
3	ҮХХ-ийн албан татвар	405.0	440.0	35.0
4	АТБӨЯХ-ийн албан татвар	105.0	120.0	15.0
5	Улсын тэмдэгтийн хураамж	83.1	141.1	58.0
6	Газрын төлбөр	230.0	350.0	120.0
7	Ус ашигласны төлбөр	340.0	400.0	60.0
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	18.5	0.0	-18.5
9	Дуудлага худалдааны орлого	114.3	268.0	153.7
10	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	45.0	45.5	0.5
11	Шууд бус орлого	148.6	205.2	56.6
12	Үйл ажиллагааны орлого	314.4	293.6	-20.8
13	Бууны албан татвар	5.4	5.0	-0.4
14	ТТАМНАТ	30.5	24.0	-6.5

15	Хог хаягдлын хураамж	102.8	119.0	16.2
Татварын орлогын нийт дүн		4,967.2	6,017.0	1,049.8
1	Түрээсийн орлого	61.0	60.0	-1.0
2	Хүү, торгуулийн орлого	590.0	564.0	-26.0
Татварын бус орлогын нийт дүн		651.0	624.0	-27.0

Хүснэгтээс харахад: Өмнөх онтой харьцуулахад татварын болон татварын бус орлогын төлөвлөгөөг 18.2% буюу нийт 1,022.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

1.3 Аймгийн төсвийн суурь зардлыг Сангийн яамнаас хянасан хязгаараас нэмэгдүүлэн баталж, зарцуулсан байна

2021 оны орон нутгийн төсвийн зарлага төлөвлөлтийн талаар:

Аймгийн 2021 оны төсвийн нийт зарлага анх 16,924.0 сая төгрөгөөр батлагдаж ирсэн байна. Үүнд: орон нутгийн суурь зарлага 6,872.2 сая, ТЗШ-ийн байгууллагын зарлага 8,538.2 сая, ОНХС-ийн зарлага 1,513.6 сая төгрөгөөр тус тус батлагдсан байна.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн суурь зардлыг Сангийн яамны хянасан дүнгээс аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нийт 2,309.1 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна.

УИХ болон аймаг, сумдын баталсан зарлагын төсвийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

/сая төгрөгөөр/

Д/д	Зардлын төрөл	2020 онд батлагдсан төсөв		Зөрүү
		УИХ-аар батлагдсан	Аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор нэмэгдүүлэн баталсан	
1	Орон нутгийн суурь зарлага	6,872.2	7,255.2	383.0
2	Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага	8,538.2	8,538.2	0.0
3	Аймаг, сумын ОНХС-гийн зарлага	1,513.6	1,895.4	381.8
4	Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	0.0	1,188.6	1,188.6
5	Сумдын СХС-гийн зарлага	0.0	355.7	355.7
Нийт дүн		16,924.0	19,233.1	2,309.1

Хүснэгтээс харахад: Сангийн яамнаас хянасан төсвийг 14% буюу нийт 2,309.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталсан байна. Зардлыг нэмэгдүүлэхдээ дараах байгууллагуудын урсгал зардлаас нийт 524.0 сая төгрөгийг хассан. Үүнд: ЦСҮТ ОНӨҮГ-аас 23.1 сая, Боржигин чуулгаас 97.0 сая, ГХБХБГ-ын тогтмол зардлаас 5.0 сая, Мал эмнэлгийн вакцины зардлаас 27.2 сая, ЕБС-иудын тогтмол зардлаас 218.4 сая, СӨББ-ын тогтмол зардлаас 91.5 сая, сумдын Соёлын төвүүдийн тогтмол зардлаас 6.8 сая, сумдын ЭМТ-ийн тогтмол зардлаас 30.0 сая, БТСГ-ын тогтмол зардлаас 25.0 сая төгрөг.

Нэмэгдүүлж баталсан зардлыг байгууллагаар нь авч үзвэл:

1. Орон нутгийн суурь зарлагыг нийт 907.0 сая төгрөгөөр. Үүнд:

- Аймгийн ИТХ--д 169.0 сая,
- Аймгийн ЗДТГ-т 111.0 сая,
- ОНӨГ-т 30.0 сая,
- Автозамын санд 97.3 сая,
- Сум дундын ойн ангийн төсвийг 20.0 сая

- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардал 6.5 сая
 - ЗДНСан 101.2 сая
 - Сүмбэр сумын ИТХ 38.2 сая, ЗДТГ 78.6 сая, “Тохижилт-Сүмбэр” ОНӨААТҮГ 83.7 сая,
 - Баянтал сумын ИТХ 20.0 сая, ЗДТГ 7.5 сая,
 - Шивээговь сумын ИТХ 39.0 сая, ЗДТГ 35.0 сая
 - Биеийн тамир спортын газарт 60.0 сая,
 - Орон нутгийн Музей 6.4 сая
 - Орон нутгийн Номын сан 3.6 сая
- 2. Аймаг, сумдын ОНХС-ийн зарлагыг нийт 381.8 сая төгрөгөөр. Үүнд:**
- Аймгийн ОНХС 33.1 сая,
 - Сүмбэр сумын ОНХС 295.0 сая,
 - Шивээговь сумын ОНХС 29.7 сая,
 - Баянтал сумын ОНХС 24.0 сая
- 3. Орон нутгийн хөрөнгө оруулалт 1,188.6 сая төгрөгөөр**
- 4. Сумдын СХС-гийн зарлагыг нийт 355.7 сая төгрөгөөр. Үүнд:**
- Сүмбэр сумын СХС 201.7 сая,
 - Шивээговь сумын СХС 43.0 сая,
 - Баянтал сумын СХС 111.0 сая,

Тайлант онд төсвийн тодотгол хийж, аймгийн ИТХТ-ийн 2021.07.23-ны өдрийн 05, Сүмбэр сумын ИТХ-ын 2021.08.13-ны өдрийн 03, Шивээговь сумын 2021.08.10-ны өдрийн 04, Баянтал сумын 2021.07.30-ны өдрийн 08 дугаар тогтоолоор суурь зарлагыг 357.6 сая, тусгай зориулалтын шилжүүлгийн зарлагыг 347.7 сая, Орон нутгийн хөрөнгө оруулалтын зарлагыг 755.1 сая, аймаг, сумдын ОНХС-гийн зарлагыг 377.2 сая, сумдын СХС-гийн зарлагыг 3.3 сая, нийт 1,840.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 21,074.0 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн ИТХТ-ийн хурлаар төсөвт өөрчлөлт оруулаагүй байхад сумдын ИТХ-аас тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагын төсвийг 200.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн нийт 21,274.5 сая төгрөгөөр баталсан байна.

Аймгийн 2021 оны тодотгосон төсвийг хүснэгтээр харуулбал

Хүснэгт №4		/сая төгрөгөөр/		
Д/д	Зардлын төсөв	Батлагдсан төсөв	Тодотгосон төсөв	Зөрүү
1	Орон нутгийн суурь зарлага	7,255.2	7,612.8	357.6
2	Тусгай зориулалтын шилжүүлгийн зарлага	8,538.2	9,086.4	548.2
3	Аймаг, сумын ОНХС-гийн зарлага	1,895.4	2,272.6	377.2
4	Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалт	1,188.6	1,943.7	755.1
5	Сумдын СХС-ийн зарлага	355.7	359.0	3.3
Нийт дүн		19,233.1	21,274.5	2,041.4

Хүснэгтээс харахад батлагдсан төсвийг 2,041.4 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд:

1. Орон нутгийн суурь зарлагыг нийт 357.6 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. /Аймгийн ИТХ 37.4 сая, АЗДНС-230.5 сая, Насан туршийн боловсролын төв 11.3 сая, аймгийн Соёлын газар 17.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ-15.0 сая, Баянтал сумын ЗДТГ 13.0 сая, Шивээговь сумын ИТХ 5.0 сая, ЗДТГ-35.2 сая, Баянтал сумын 4 дүгээр сургуулийн тогтмол зардлыг 14.0 сая, нийт 364.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж, АЗДТГ-ын зардлыг 20.8 сая төгрөгөөр бууруулсан байна/
2. ТЗШ-ийн байгууллагын зарлагыг нийт 548.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. Үүнд: СӨББ-ын зардлаас 605.2 сая, аймгийн ГХБХБГ-аас 4.8 сая, ГБХЗХГ 1.3 сая, нийт 611.3 сая төгрөгөөр бууруулж, ЕБС-иудын төсвийг 1,159.5 сая төгрөгөөр нэмэгдүүлэн баталсан байна

3. Аймаг, сумын ОНХС-ийн зарлагыг нийт 377.2 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. /АОНХС 180.0 сая, Баянтал сумын ОНХС 9.5 сая, Сүмбэр сумын ОНХС 126.5 сая, Шивээговь сумын ОНХС-д 61.2 сая төгрөг /
4. Орон нутгийн хөрөнгө оруулалт 755.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.
5. Баянтал сумын СХС-гийн зарлагыг нийт 3.3 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн

1.4 Орон нутгийн төсвийн тэнцлийн алдагдлыг нөхөх эх үүсвэрийг 20.7 сая төгрөгөөр дутуу тооцсон байна.

Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2020 онд татварын орлогын төлөвлөгөөг 944.0 сая төгрөгөөр давуулан биелүүлж, орон нутгийн төсвийн байгууллагууд 626.7 сая төгрөгийн зардлыг хэмнэж ажилласан бөгөөд Сүмбэр сум тэнцлийн ашиг эх үүсвэрийг нийт 17.9 сая төгрөгөөр дутуу баталсан байна.

2020 оны тэнцлийн ашгийг аймаг, сумдаар нь хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №5 /сая төгрөгөөр/

Д/д	Аймаг, сумдын нэр	2020 оны		Нийт дүн
		Давсан орлого	Хэмнэгдсэн зардал	
1	Аймаг	683.6	515.5	1,199.0
2	Сүмбэр сум	230.3	62.6	292.9
3	Баянтал сум	9.3	23.0	32.3
4	Шивээговь сум	20.8	25.6	46.5
Нийт		944.0	626.7	1,570.7

Хүснэгтээс харахад: 2020 онд 1,570.7 сая төгрөгийн тэнцлийн ашигтай гарсан байна. Нийт тэнцлийн ашгийн 76%-ийг аймаг, 18%-ийг Сүмбэр сум, 2%-ийг Баянтал сум, 4%-ийг Шивээговь сум тус тус эзэлж байна.

2020 оны тэнцлийн ашгийг аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болгон батлахдаа Сүмбэр сум 17.9 сая төгрөгөөр дутуу тодотгож баталсан байна. Өмнөх онд ОНХС-ийн ажлууд тайлант ондоо багтаж хийгдээгүй, он дамжсанаас шалтгаалан нийт 414.9 сая төгрөгийн дансны үлдэгдэлтэй гарсан байна. Үүнд: Аймгийн ОНХС 181.5 сая, Сүмбэр сумын ОНХС 142.8 сая, Баянтал сумын ОНХС 24.6 сая, Шивээговь сумын ОНХС 66.0 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №6 /сая төгрөгөөр/

Д/д	ОНХС-гийн нэр	2019 оны ОНХС-ийн дансны үлдэгдэл	Эхний үлдэгдлээс санхүүжихээр баталсан	Зөрүү
1	Аймгийн ОНХС	181.5	181.5	0.0
2	Сүмбэр сумын ОНХС	142.8	140.0	2.8
3	Баянтал сумын ОНХС	24.6	24.6	0.0
4	Шивээговь сумын ОНХС	66.0	66.0	0.0
Нийт дүн		414.9	412.1	2.8

Хүснэгтээс харахад: ОНХС-гийн эхний үлдэгдлээс санхүүжих зардлыг нийт 412.1 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Сүмбэр сумын ОНХС нь 2019 оны төсвийг батлахдаа эх үүсвэрийг 2.8 сая төгрөгөөр дутуу баталсан байна

Бүлэг 2

Орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ биелсэн боловч зарим зарим нэр төрлийн татварын орлого тасарсан байна.

2.1 Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 46% буюу 2,772.8 сая төгрөгөөр давж биелсэн боловч 3 нэр төрлийн татварын орлого 66.2 сая төгрөгөөр тасарсан байна.

2021 онд орон нутгийн төсөвт татварын болон татварын бус орлогод нийт 6,017.1 сая төгрөгийг бүрдүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,789.9 сая төгрөгийн орлого бүрдүүлж, орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 2,772.8 сая төгрөг буюу 46%-иар давж биелсэн байна.

2021 оны орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №7 /сая төгрөгөөр/

Он	Татварын орлого			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2021	6,017.1	8,789.9	2,772.8	46.0
2020	4,967.2	5,754.8	787.6	15.9



Дүрслэлээс харахад: орон нутгийн татварын орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 21.1%-иар нэмэгдүүлэн төлөвлөсөн ба өмнөх оны гүйцэтгэлээс 52.7%-иар өссөн байна. 2020 онд орлогын төлөвлөгөөний биелэлт 15.9%-тай байсан бол тайлант онд төвлөрүүлсэн орлогын гүйцэтгэл 46.0%-иар давж биелсэн байна.

2021 оны татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг нэр, төрлөөр нь

Хүснэгт №8 /сая төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал, болон тэдгээртэй адилтгах орлого	3,780.0	4,817.5	1,037.5	27.4
Үйл ажиллагааны орлого	82.1	190.0	107.9	131.4
Хөрөнгийн орлого	211.5	279.6	68.1	32.2
Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	45.5	223.4	177.9	391.0
Шууд бус орлого	205.2	147.3	-57.9	-28.2
Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-174.4	-174.4	0.0	0.0

Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	440.0	536.8	96.8	22.0
Бууны албан татвар	5.0	4.6	-0.4	-7.2
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	120.0	112.1	-7.9	-6.6
Малд ногдуулах албан татвар		83.3	83.3	0.0
Улсын тэмдэгтийн хураамж	141.1	248.7	107.6	76.2
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	24.0	28.0	4.0	16.5
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	119.0	143.9	24.9	21.0
Газрын төлбөр	350.0	366.1	16.1	4.6
Дуудлага худалдаа	268.0	1,094.9	826.9	308.5
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	0.0	5.3	5.3	0.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	400.0	682.7	282.7	70.7
Нийт дүн	6,017.1	8,789.9	2,772.8	46

Хүснэгтээс харахад: татварын орлогын төлөвлөгөөний биелэлт нийт дүнгээрээ 2,772.8 сая төгрөгөөр давж биелсэн байна. Тухайлбал: орлогын 13 нэр төрөл 4.6-391%-иар буюу 16.1-177.9 сая төгрөгөөр тус тус давж биелсэн бол орлогын 3 нэр төрөл 6.6-28.2%-иар буюу 0.4 -57.9 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн шалтгааныг тодруулбал:

- Өмнөх оны дутуу төлөгдсөн татварын орлогууд он дамжин төлөгдсөн
- Дуудлага худалдааны орлого төлөвлөснөөс давж биелсэн байна.
- Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөө нь сумдын нэг толгой малд ногдох татварын хувь хэмжээ тогтоосон тогтоол нь Хууль зүйн яаманд хянагдаж нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээний акт болоогүй байсан тул 2021 оны төсөвт тусган батлуулаагүй 83.3 сая төгрөг
- Ан амьтны нөөц ашигласны албан татвар төлөвлөгдөөгүй 2020 оны Сүмбэр сумаас хийгдсэн агнуурын гэрээний дагуу үлдэгдэл төлбөр төвлөрсөн

Харин орлогын төлөвлөгөө тасарсан шалтгааныг тодруулбал:

- Шууд бус орлого нь улс даяар ковид 19 цар тахал өвчин гарсантай холбоотойгоор татвар төлөгчийн тоо буурсан
- Бууны албан татвар (цагдаагийн галт зэвсгийн бүртгэл зөрүүтэй, галт зэвсгээ шилжүүлсэн иргэн цагдаагийн байгууллагад бүртгэлээ хийлгээгүй
- Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар ашиглагдахгүй замын хөдөлгөөнд оролцохгүй болсон 78 тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасагдахаар хүлээгдэж байгаа бөгөөд ногдсон татварыг төлөөгүй

Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №9		/сая төгрөгөөр/					
№	Орлогын нэр төрөл	2020 он		2021		Зөрүү	
		Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц	Төлөв	Гүйц
1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	3,220.0	3,736.7	3,780.0	4,817.5	560.0	1,080.8
2	ХХОАТ-ын буцаан олголт	-195.4	-195.4	-174.4	-174.4	21.0	21.0
3	ҮХХ-ийн албан татвар	405.0	373.8	440.0	536.8	35.0	163.0
4	АТБӨЯХ-ийн албан татвар	105.0	113.3	120.0	112.1	15.0	-1.2
5	Улсын тэмдэгтийн хураамж	83.1	74.2	141.1	248.7	58.0	174.5

6	Газрын төлбөр	230.0	269.7	350.0	366.1	120.0	96.4
7	Ус ашигласны төлбөр	340.0	350.6	400.0	682.7	60.0	332.1
8	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	18.5	18.5	0.0	5.3	-18.5	-13.2
9	Дуудлага худалдааны орлого	114.3	195.5	268.0	1,094.9	153.7	899.4
10	Хөрөнгө борлуулсны орлогын албан татвар	45.0	70.8	45.5	223.4	0.5	152.6
11	Шууд бус орлого	148.6	294.9	205.2	147.3	56.6	-147.6
12	Үйл ажиллагааны орлого	314.4	317.2	293.6	469.7	-20.8	152.5
13	Бууны албан татвар	5.4	5.0	5.0	4.6	-0.4	-0.4
14	ТТАМНАТ	30.5	15.1	24.0	28.0	-6.5	12.9
15	Хог хаягдлын хураамж	102.8	114.8	119.0	143.9	16.2	29.1
16	Малд ногдуулах албан татвар	0.0	0.0	0.0	83.3	0.0	83.3
Татварын орлогын нийт дүн		4,967.2	5,754.7	6,017.0	8,789.9	1,049.8	3,035.2

Хүснэгтээс харахад: Татварын орлого нийт дүнгээрээ өмнөх онтой харьцуулахад 1,049.8 сая төгрөгөөр илүү төлөвлөгдсөн ба гүйцэтгэл 3,035.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Тухайлбал: өмнөх оноос татварын 11 нэр төрлийн орлогыг 0.5-560.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 4 нэр төрлийн орлогыг 0.4-20.8 сая төгрөгөөр бууруулж төлөвлөсөн ба гүйцэтгэлээр 12 нэр төрлийн орлого 12.9 -1,080.8 сая төгрөгөөр нэмэгдэж, 4 нэр төрлийн орлого 0.4-147.6 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Зарим орлогын төлөвлөгөө өмнөх оны дүнгээс давж биелсэн нь урьд оны өр төлбөр барагдсанаас шалтгаалсан байна. Тухайлбал:

- Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын татвар 1,080.8 сая аж ахуй нэгж байгууллагууд өмнөх оны өр төлбөр барагдуулсан /
- Газрын төлбөр 120.0 сая /өмнөх оны өр барагдсан /
- Бусад татварын орлогуудыг бодит тоон мэдээлэлд үндэслэн тооцолгүй төлөвлөж баталсан байна.

2.2. Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 51.0 сая төгрөг буюу 7.8%-иар давж биелсэн боловч түрээсийн орлогын төлөвлөгөө тасарсан байна.

2021 онд Сангийн яамнаас орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө 560.0 сая төгрөгөөр хянагдаж ирсэн бөгөөд аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 64.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 624.0 сая төгрөгөөр баталсан байна.

Орон нутгийн татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №10

/сая төгрөгөөр/

Он	Татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл		
	Төлөвлөгөө	.Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2021	624.0	1,202.4	192.6
2020	651.0	702.0	107.8

Хүснэгтээс харахад: 2021 онд татварын бус орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 4.1% буюу 27.0 сая төгрөгөөр бууруулан баталсан бөгөөд гүйцэтгэлээр тайлант оны орлогын төлөвлөгөөг 92.6%-иар давуулан биелүүлсэн байна.

2021 оны татварын бус орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг татварын нэр төрлөөр нь гаргасан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №11


/сая төгрөгөөр/

Үзүүлэлт		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
Татварын бус орлого		624.0	1,202.4	578.4
2.1.	Хүү, торгуулийн орлого	564.0	1,152.1	588.1
2.2.	Түрээсийн орлого	60.0	50.3	-9.7

Хүснэгтээс харахад татварын бус орлого нийт дүнгээрээ 578.4 сая төгрөгөөр давж биелсэн боловч түрээсийн орлогын төлөвлөгөө тасарсан байна. Тухайлбал, хүү, торгуулийн орлого 578.4 сая төгрөгөөр давж биелсэн бол түрээсийн орлого 9.7 сая буюу 16.1 %-иар тасарсан байна. Хүү, торгуулийн орлогын төлөвлөгөө давж биелсэн нь өмнөх оны гүйцэтгэлд үндэслэж төлөвлөдөгтэй холбоотой, түрээсийн орлого биелээгүй нь “Чойр хайрхан” ХХК түрээсийн өр төлбөрөө барагдуулаагүйгээс шалтгаалсан байна.

2021 оны хүү, торгуулийн орлогын, гүйцэтгэлийг эх үүсвэрээр нь өмнөх онтой харьцуулсан судалгааг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл №2



Дүрслэлээс харахад: Бусад нэр заагдаагүй орлого нь өмнөх оноос 103.7 сая төгрөгөөр буюу 310%-иар өссөн нь АИТХ-ын 2021.07.23-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор орон нутгийн чанартай авто зам, замын байгууламж ашиглаж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын тээврийн хэрэгслээс авах авто зам ашигласны төлбөрийн хэмжээг тогтоосонтой холбоотой байна.

Аймгийн Цагдаагийн хэлтсийн хүү торгуулийн орлого өмнөх оноос 350.8 сая төгрөгөөр буюу 78.0 хувиар давж биелсэн нь тайлант онд Өршөөлийн хуулиар төлөгдөөгүй торгуулийн 50.0 хувийг төлбөл, 50.0 хувийг чөлөөлсөн, өмнөх оны торгуулийн төлбөрийг авто машин зарах болон нэр шилжүүлэхэд төлүүлсэн зэрэг нь нөлөөлсөн байна.

2.3 Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 13.0% буюу 53.5 сая төгрөгөөр давж биелсэн байна.

2021 онд төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг 31.5 сая төгрөгөөр баталсан ба аймаг, сумдын ИТХ-ын тогтоолоор 20.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 51.6 сая төгрөгөөр батлуулсан байна. Автозамын сангийн орлогыг 20.0 сая төгрөгөөр нэмж батлуулсан байна.

Төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №12

/сая төгрөгөөр/

№	Байгууллага	2021 он		2020 он	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Орон нутгийн төсөвт байгууллагын өөрийн орлого					
1	АЗДТГ	0.7	2.1	0.7	2.3
2	БТСГ			22.0	18.5
3	Цөм сүрэг үржлийн төв	30.9	26.3	30.9	20.6
4	Авто зам	20.0	49.6	20.0	16.9
Дүн		51.6	78.0	73.6	58.3
Сумдын сангийн орлого					
1	Сумдын сум хөгжүүлэх сан	359.0	386.1	277.3	164.1
Дүн		359.0	386.1	277.3	164.1
НИЙТ ДҮН		410.6	464.1	350.9	222.4

Хүснэгтээс харахад: 2021 оны өөрийн орлогын төлөвлөгөөг өмнөх оноос 17.0%-иар буюу 59.7 сая төгрөгөөр нэмж төлөвлөсөн байна. Энэ нь Сумдын сум хөгжүүлэх сангуудын орлогыг /зээлийн эргэн төлөлтийг/ нэмж баталсантай холбоотой юм.

Өөрийн орлогын төлөвлөгөө нийт 53.5 сая төгрөг буюу 13.0%-иар давж биелсэн байна. Тухайлбал: АЗДТГ 1.4 сая Авто замын сан 29.6 сая, Сумдын Сум хөгжүүлэх сангуудын орлого 27.1 сая, нийт 58.1 сая төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Харин өөрийн орлогын төлөвлөгөөг “Цөм сүргийн үржлийн төв” ОНӨҮГ 4.6 сая төгрөгөөр тасалсан ба жил бүр зөрчил давтагдсаар байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2-т “Бүх шатны төсвийн захирагч төсвийн хэрэгжилтийн талаар дараах үүрэг хүлээнэ”, 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэснийг тус тус зөрчсөн байна.

2.4. 2021 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг өмнөх оноос 531.9 сая төгрөгөөр буурсан байна.

2021 онд улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг анх 1,062.6 сая төгрөгөөр батлагдсан боловч төсвийн тодотголоор 550.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 1,613.1 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №13

/сая төгрөгөөр/

Он	Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг		
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Биелэлтийн хувь
2021	1,613.1	1,613.1	-
2020	2,145.0	2,145.0	-

Тус аймаг нь 2020 онд улсын төсвөөс 2,145.0 сая, тайлант онд улсын төсвөөс 1,613.1 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авсан ба өмнөх онтой харьцуулахад 24.7%-иар буурсан байна.

2.5. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэг бүрэн санхүүжигдсэн байна.

2021 онд орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох орлогын шилжүүлэгт дотоодын НӨАТ-ын 5%, газрын тосны нөөц ашигласны төлбөрийн 30%, АМНАТ-ийн хуваарилалт 5%, АМХТЗ-ийн 50-100 хувь, АМАТЗ-ийн 50 хувь, АМНАТ-Мега төслүүдээс хассан зөрүүний 10хувь, ОУБ-аас сумдын ОНХС-д олгох урамшуулал зэрэг нийт 1,513.6 төгрөгөөр батлагдсан ба сая, төсвийн тодотголоор 44.4 сая төгрөгөөр нэмэгдүүлж 1,558.0 сая төгрөг хуваарилагдсан байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн шилжүүлгийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №14

/сая төгрөгөөр/

Он	ОНХНС-гийн санхүүжилт			
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлтийн хувь
2021	1,558.0	1,558.0	0.0	100
2020	1,139.9	1,016.0	123.9	89.1

Хүснэгтээс харахад: 2021 онд ОНХНС-гаас олгох санхүүжилт өмнөх оноос 36.6%-иар нэмэгдэж батлагдсан ба гүйцэтгэлээр санхүүжилт бүрэн олгогдсон байна.

2.6. ЭМДС-гаас авах санхүүжилт 25.5 сая төгрөгөөр дутуу олгогдсон байна.

2021 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг 8,538.2 сая, төсвийн тодотголоор 548,2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 9,086.4 сая төгрөгөөр баталсан байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг өмнөх онтой харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №15		/сая төгрөгөөр/		
Он	Тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилт			Биелэлтийн хувь
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
2021	9,086.4	9,060.9		99.7
2020	9,433.7	9,433.7		100.0

Хүснэгтээс харахад: 2021 онд тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын санхүүжилтийг өмнөх оноос 3.6%-иар бууруулж төлөвлөсөн байна.

Харин тайлант онд гүйцэтгэлээр 9,060.9 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 25.5 сая төгрөгийн санхүүжилт дутуу олгогдсон байна. Энэ нь Ковид-19 цар тахлын улмаас сумын ЭМТ-үүд эмнэлгийн анхан шатны шинжилгээ, тусламж үйлчилгээгээ үзүүлээгүйгээс ЭМДС-гаас дутуу санхүүжилтээ аваагүй байна/

2.7. Тэнцлийн ашгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

2020 онд татварын давсан орлогоос нийт 944.0 сая /аймаг 683.6 сая, Сүмбэр сум 230.3 сая, Баянтал сум 9.3 сая, Шивээговь сум 20.8 сая/ төгрөгийг, орон нутгийн төсвийн байгууллагуудын хэмнэлтээс буцаан төвлөрүүлсэн нийт 626.7 сая /аймаг 1,199.0 сая, Сүмбэр сум 292.9 сая, Баянтал сум 32.3 сая, Шивээговь сум 46.5 сая/, нийт 1,570.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт бүрэн төвлөрүүлсэн байна.

Орон нутгийн төсвийг үр ашигтай, үнэн зөв зарцуулсан эсэх

Бүлэг 3

Төсвийн хөрөнгийг батлагдсан төсвийн хүрээнд зарцуулсан боловч зарим зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.

3.1 Аймгийн СТСХ нь байгууллагуудын хүсэлтийн дагуу батлагдсан төсвийг зардлын бүлэг хооронд гүйлгэн зохицуулалт хийсэн байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн ерөнхийлөн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх нийт 43 хөтөлбөрт зориулан 21,274.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 17,414.0 сая төгрөгийг урсгал зардалд, 3,501.5 сая төгрөгийг хөрөнгийн зардалд 359.0 сая төгрөгийг эргэж төлөгдөх зээлийн зардалд зарцуулахаар батлагджээ.

Төсвийн суурь зарлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой нийт 283.9 сая төгрөгийн дараах зөрчил, дутагдлууд илэрлээ. Тухайлбал:

1. УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн зарлагыг аймаг, сумдын ИТХ-аар батлахдаа орон нутгийн хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх бодлого, чиглэл баримтлаагүй, төсвийн хэмнэлтийн горимыг баримтлаагүйгээс суурь зарлагыг нийт 283.9 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна. /Аймгийн ИТХ-ын төсвийн урсгал зардалд 121.1 сая, аймгийн ЗДТГ-

ын урсгал зардалд 111.0 сая, Шивээговь сумын ИТХ 3.6 сая, ЗДТГ 35.2 сая, Баянтал сумын ЗДТГ 13.0 сая/

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх болон урсгал зардалтай холбоотой зарим зардлын өсөлт нь дараах шалтгаантай байна. Үүнд:

1. Аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт, аудитын алба, Орон нутгийн өмчийн газрын батлагдсан орон тоо Сангийн яамны хянасан дүнгээс нэмэгдсэн байна. Орон тоог хязгаараас нэмэгдүүлж баталдаг асуудал урд онуудад мөн гарч байсныг төсвийн төсөлд өгсөн саналуудад жил бүр тусгаж байсан. Энэ нь орон нутаг төсвөө хязгаарт багтаах тухай хуулийн заалтад нийцүүлэн боловсруулахгүй байгаатай холбоотой ч, Сангийн яам орон тоог бодит нөхцөл байдалтай уялдуулан тооцохгүй байгаа нь мөн нөлөөлсөн байна.
2. Аймгийн ИТХ нь МУЗЗНДНТУТХ-ын 20.3-т “Хурлын Тэргүүлэгчид ажлын албатай байх бөгөөд түүний орон тоо, цалингийн санг Төсвийн тухай хуулийн 10.1.2-т заасан тухайн жилийн төсвийн хязгаарт багтаан Тэргүүлэгчид өөрөө тогтооно” гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.
3. Санхүү хяналт, аудитын албаны орон тоо нь батлагдаж ирдэггүй боловч цалин сангийн зардал нь дутуу батлагдан ирдэг байна.
4. Орон нутгийн өмчийн газар бүтцийн өөрчлөлтөөр өмнө Орон нутгийн өмчийн алба 3 орон тоотой байснаас өөр нэмэгдсэн орон тоо байхгүй байна.
5. Аймгийн ИТХ урсгал зардлыг намын суудлын мөнгөөр нэмэгдүүлсэн байна. Орон нутгийн ИТХ-д суудалтай намд санхүүгийн дэмжлэг олгох ямар нэгэн хууль, эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8, 4.1.30, 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.6.6 дахь заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд төсвийг үндэслэлтэй баталж, төсөв батлахдаа төсвийн хязгаарыг баримтлан тэвчиж болох зардлуудыг нэмэгдүүлэхгүй байх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлыг 25,418.9 сая төгрөгөөр тайлагнасан ба, өмнөх онтой харьцуулахад үйл ажиллагааны зардал 2,281.5 сая төгрөгөөр өссөн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар зардлын данстай холбоотой нийт 462.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрч 334.6 сая төгрөгийн алдаа, зөрчлийг залруулж, 66.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгч, 61.4 сая төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө

Энэ нь Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй, зардлыг ангилал зөрүүтэй бүртгэсэн, холбогдох эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй хөрөнгө зарцуулсан зөрчлүүд байна. Үүнд:

- “Ус-Ду” ОНӨААТҮГ нь зардлыг ангилал зөрүүтэй бүртгэснээс 334.6 сая төгрөгийг залруулсан
- Засгийн газрын 43 дугаар тогтоолыг хэрэгжүүлж ажиллаагүй 66.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага өгсөн. Үүнд: АИТХ-29.2 сая, АЗДТГ-12.7 сая, Сүмбэр сумын ЗДТГ-24.9 сая
- Эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй төсвийн бүлэгт хооронд шилжүүлж зарцуулсан 61.4 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнд: Ус-Ду ОНӨААТҮГ-26.6 сая, ГБХЗХГ-34.8 сая

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 16 дугаар зүйлийн 16.5.5, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4 дэх заалтуудыг зөрчсөн байна.

3.2 Төсвийн хэмнэлтийн 683.7 сая төгрөгийн 3.5 хувь нь бодит бус хэмнэлт байна.

ТЕЗ нь 2021 онд 21,274.6 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж, 19,377.2 сая төгрөг зарцуулж, 1,897.4 сая төгрөгийн хэмнэлттэй тайлагнасан байна.

2021 оны батлагдсан төсөв, гүйцэтгэлийг харьцуулсан судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 16 /сая төгрөгөөр/

Төсвийн захирагч	Батлагдсан төсөв	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Орон нутгийн төсвийн байгууллага	12,188.1	10,343.9	1,844.2	53.4
Тусгай шилжүүлгийн байгууллага	9,086.5	9,033.3	53.2	46.6
Нийт дүн	21,274.6	19,377.2	1,897.4	100

Хүснэгтээс харахад: 2021 оны төсвийн гүйцэтгэл 19,377.1 сая төгрөг буюу 91.0%-ийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: орон нутгийн байгууллага 10,343.9 сая төгрөг буюу 53.4 хувь, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллага 9,033.3 сая төгрөг буюу 46.6 хувийг тус тус эзэлж байна

Тайлант онд нийт 1,897.4 сая төгрөгийн хэмнэлттэй ажилласан ба үүнээс 25.6 сая төгрөгийг улсын төсөвт, 1,186.1 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, 2.0 сая төгрөгийг сумдын ЭМТ-үүд үлдэгдлээр тайлагнаж, бодит бус хэмнэлт 683.7 сая төгрөг байна. Үүнд:

- 37 байгууллагын 361.6 сая төгрөгийн үлдэгдэл нь бодит хэмнэлт бөгөөд цалин хөлс, нэмэгдэл урамшил, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, засварын зардал, томилолтын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, бараа ажил үйлчилгээний бусад зардал, төрийн өмчит байгууллагад олгох татаас урсгал шилжүүлэг зэрэг зардлууд хэмнэгдсэн байна
- Аймгийн Орон нутгийн хөрөнгө оруулалтаас 855.6 сая төгрөгийн төлөвлөсөн ажлууд хугацаандаа хийгдэлгүй он дамжсан
- Сумын ЭМТ-үүд нь 2.0 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Харин 683.7 сая төгрөг нь бодит бус хэмнэлт бөгөөд байгууллага болон эх үүсвэрээр нь харуулбал:

- Үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг нийт 4.6 сая төгрөгөөр тасалсантай холбоотой "ЦСҮТ" ОНӨҮГ-ын 4.6 сая төгрөгийн зардлыг санхүүжүүлээгүй
- Сүмбэр, Шивээговь сумдууд СХС-гаас зээл олгоогүйгээс 282.8 сая
- Сумдын Эрүүл мэндийн төв эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлээгүйгээс ЭМДС-гаас 25.5 сая төгрөгийн санхүүжилтийг дутуу авсан /Шивээговь сумын ЭМТ 19.2 сая, Баянтал сумын ЭМТ 6.3 сая/
- Аймаг, сумдын ОНХС-гийн ажил төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, он дамжсанаас 370.8 сая төгрөгийг тус тус хэмнэсэн байна.

Аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл ангиар хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 17 /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
----------	-----------------------	-----------	-------

НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	21,274.6	19,377.2	1,897.4
УРСГАЛ ЗАРДАЛ	17,414.0	16,872.3	541.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	16,800.3	16,274.2	526.1
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	10,188.0	10,044.1	143.9
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,329.7	1,280.2	49.5
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	1,499.4	1,458.6	40.8
Хангамж, бараа материалын зардал	292.8	283.4	9.4
Нормативд зардал	223.0	207.0	16.1
Эд хогшил, урсгал засварын зардал	365.1	362.5	2.7
Томилолт, зочны зардал	67.9	56.3	11.6
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	556.8	541.9	14.9
Бараа үйлчилгээний бусад зардал	2,277.5	2,040.3	237.2
ТАТААС	154.6	153.0	1.6
Төрийн өмчит байгууллагад олгох татаас	2.5	0.9	1.6
Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	152.1	152.1	0.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	459.1	445.0	14.1
Засгийн газрын урсгал шилжүүлэг	102.1	102.0	0.0
Бусад урсгал шилжүүлэг	357.1	343.0	14.1
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	3,501.4	2,428.7	1,072.8
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	359.1	76.3	282.8

2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн зарим зардлын гүйцэтгэл, хэмнэлтийн шалтгааныг харьцуулан судалж үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардал-193.4 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь 6 байгууллага 15 орон тоо дутуу ажилласнаас хэмнэсэн байна.
- Тогтмол зардал – 40.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь боловсролын байгууллагууд тайланд онд, халаалт усны зардлыг хэмнэсэнтэй холбоотой
- Нормативд зардал- 16.1 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь сургууль цэцэрлэг хичээллээгүй, дотуур байрны хүүхдийн хоол, үдийн цайны зардлын хэмнэлтийг улсын төсөвт буцаан татсантай холбоотой.
- Бараа үйлчилгээний бусад зардал – 281.5 сая төгрөг хэмнэсэн нь Ковид-19 цар тахлын улмаас хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлээгүйтэй холбоотой /АОНХС 145.5 сая, сумдын ОНХС 8.0 сая, БХНСАХЗ 20.8 сая, Автозамын сангийн 39.7 сая, бусад байгууллагын 23.2 сая/
- Хөрөнгийн зардал 1,072.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь аймаг, сумдын ОНХС болон орон нутгийн хөрөнгө оруулалтын ажил он дамжиж хийгдэх болсон, гэрээний хэмнэлт зэргээс үүссэн байна.
- Эргэж төлөгдөх зээлийн зардал 2,82.8 сая төгрөгөөр хэмнэгдсэн нь Сүмбэр, Шивээговь сумд тайлант онд шинээр зээл олгоогүйтэй холбоотой байна.

3.3 Нэмэлт санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж 5.8 сая, ЗГНХ, ЗДНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчаас 114.3 сая, дээд шатны төсвийн захирагчаас 644.5 сая, үндсэн

үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 287.0 сая, Эрүүл мэндийн даатгалын сангаас 214.3 сая, нийт 1,265.9 сая төгрөгийн орлогыг бүртгэж тайлагнасан байна.

Үүнээс цалин хөлс, нэмэгдэл урамшууллын зардалд 64.3 сая, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардалд 25.7 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 2.0 сая, хангамж, бараа материалын зардалд 85.0 сая, нормативт зардалд 107.9 сая, эд хогшил, урсгал засварын зардалд 85.3 сая, томилолт, зочны зардалд 6.5 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардалд 232.9 сая, бараа үйлчилгээний бусад зардалд 336.5 сая, бусад урсгал шилжүүлгийн зардалд 114.1 сая, хөрөнгийн зардалд 131.8 сая, нийт 1,192.0 сая төгрөгийг зарцуулж, улсын төсөвт 33.2 сая, орон нутгийн төсөвт 39.9 сая төгрөгийг тус тус төвлөрүүлж, 0.8 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

Санхүүгийн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд нэмэлт санхүүжилтийн дансны 270.0 сая төгрөгийн орлого, байгууллагуудын зардлын давхардсан гүйлгээг устгасан байна.

Аймаг, сумдын нэмэлт төвлөрүүлэлтийн дансны эхний үлдэгдэл 119.4 сая төгрөг байснаас тайланд онд аймаг 31.0 сая, сумд 8.9 сая нийт 39.9 сая төгрөгийг орлогоор төвлөрүүлж, БТСГ-т 13.1 сая, БОАЖГ-т 1.0 сая, АЗДТГ-т 4.0 сая, Сүмбэр сумын ЗДТГ-т 90.0 сая, нийт 108.1 сая төгрөгийг тус тус олгож, аймаг, сумдын ерөнхий орлогод 11.3 сая төгрөгийг төвлөрүүлж, 39.9 сая төгрөгийг үлдэгдлээр тайлагнасан байна.

ТЕЗ-дын хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрэх үр дүн зорилтод түвшинд нийцэж буй эсэх

Бүлэг 4

Төсөв захирагчдын хэрэгжүүлж буй хөтөлбөр, арга хэмжээний чанарын болон тоон үзүүлэлтэд тавих хяналт хангалтгүй байна.

4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92.0 хувьтай байна.

Аймгийн ИТХ-ын 2020оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 03 дугаар хуралдааны 03 дугаар тогтоолын 06 дугаар хавсралтаар ТЕЗ нь орон нутгийн төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүнг төлөвлөн батлуулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 25 хөтөлбөр батлагдсанаас орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох аймгийн ИТХ-ын үйл ажиллагааны 2 хөтөлбөрт хамаарах 2 арга хэмжээ, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн хэрэгжүүлэх 18 хөтөлбөрт хамаарах орон нутгийн гүйцэтгэх засаглалын удирдлагыг хэрэгжүүлэх 23 арга хэмжээ байна.

Төрийн албаны тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.3 дахь хэсэгт “Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг харьяа байгууллагын үйл ажиллагааны үр дүнгээр үнэлнэ” гэж заасны дагуу Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтэс нь ТЕЗ-ийн хэрэгжүүлэх хөтөлбөрт хамаарах орон нутгийн ТШЗ-дын байгууллагуудын ажлын биелэлтийг дүгнэн 80.3-97.0 хувьтай дүгнэсэн байна.

Жилийн эцэст байгууллагуудаас тухайн төсвийн жилд гүйцэтгэсэн ажлын тоо чанарын үзүүлэлтийн тайланг хүлээн авч Шилэн дансны нэгдсэн санд Засгийн газрын 2016 оны 29 тоот тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 3.1.11-т заасны дагуу 2021 оны жилийн эцсийн тайланг байршуулсан байна.

Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарах хөтөлбөр арга хэмжээнүүдэд орон нутгийн төсөвт байгууллагууд болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, ахмад настны хөгжил хамгаалал, нийгмийн халамж, мал эмнэлгийн үйлчилгээ, хот тохижилт, авто замын сан, мал хамгаалах сан, орон нутгийн төсвийн болон хөгжлийн

сангийн хөрөнгө оруулалт, байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээтэй холбоотой үйл ажиллагаанууд байна.

4.2 Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд бодитой үнэлгээ хийгээгүй байна.

Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д зааснаар аймгийн Засаг даргын дэргэд Санхүүгийн хяналт, аудитын алба ажиллаж байгаа ч тус алба нь 2021 оны батлагдсан хөтөлбөр, арга хэмжээ, төсвийн орлого, зарлагын хэрэгжилтэд хяналт хийгээгүй байна.

Аймгийн Засаг дарга болон сумдын Засаг дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээнд Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.5-д заасны дагуу гэрээний биелэлтэд хагас, бүтэн жилээр аймгийн ЗДТГ-ын Хяналт, шинжилгээ үнэлгээний хэлтсээс хяналт шинжилгээ үнэлгээ хийсэн боловч бодитой үнэлж чадаагүй байна.

Туайлбал: Өөрийн орлогын төлөвлөгөөгөө биелүүлж ажиллаагүй “Цөм сүргийн үржлийн төв ОНӨҮГ”, аймгийн ОНХС он дамжин хуримтлагдсаар байгаа авлага өглөгийг барагдуулах ажил хийгдээгүй, төлөвлөсөн хөрөнгө оруулалтын ажлыг хугацаанд гүйцэтгээгүй, зорилтот түвшиндээ хүрээгүй байхад төсөв захирагчдын үйл ажиллагааны хэрэгжилтийг 90-100% гэж дүгнэсэн нь бодит үнэлгээ хийгдээгүйг харуулж байна.

Иймд эрсдэлийг бууруулах зорилгоор ТЕЗ-ийн хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд хяналтыг бодитой, үр дүнтэй хэрэгжүүлэх нь зүйтэй байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-т “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, 41.2.3-т “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах”, 41.2.7 дахь хэсэгт “хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 304.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн бөгөөд зөрчлийг арилгах 3 зөвлөмжийг холбогдох албан тушаалтанд хүргүүлэв.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Аймгийн төсвийн нийт орлого төлөвлөгөөнөөс давж биелсэн ч орлогын нэр төрлөөрөө жил бүр тасарсаар байна.
2. Аймгийн төсвийн суурь зарлагыг Сангийн яамнаас тогтоосон хязгаараас нэмэгдүүлэн баталж, зарцуулсан байна.
3. Сүмбэр сум ОНХС-гийн эхний үлдэгдэл, өмнөх оны тэнцлийн ашгийг дутуу тодотгосон байна.
4. Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөвт хамаарах хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилт 92 хувьтай байна
5. Хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэд дотоод хяналт, шалгалт хариуцсан алба, хэлтсүүд хуулийн дагуу хяналт тавьж ажиллаагүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ

Аудитын дүнд үндэслэн дор дурдсан албан тушаалтанд дараах зөвлөмжийг өгч байна.

Төсвийн ерөнхийлөн захирагч бөгөөд аймгийн Засаг даргад Г.Батзам танаа:

1. Татварын болон татварын бус орлого, төсөвт байгууллагын өөрийн орлогын төлөвлөгөөг үндэслэлтэй төлөвлөж, давагдашгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах, татварын орлогыг нэр төрлөөр нь бүрдүүлж ажиллах
2. ОНХС-ийн эхний үлдэгдэл, өмнөх оны тэнцлийн ашгийг үнэн зөв тооцох
3. Хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг хариуцсан алба, хэлтсүүдээр үр дүнтэй хэрэгжүүлэх